

Энэ товчлуур ямар үүрэгтэй вэ?

2019 оны 11-р сар

Аливаа аюулгүйн системийн гүйцэтгэх үүргийг маш нарийн тодорхойлох шаардлагатай ба системийг идэвхжүүлсэн тохиолдолд найдвартайгаар хариу үйлдэл үзүүлэх ёстой. Тухайлбал зогсох команд (ESD, аваарын зогсолт) өгөхөд яг дүрмийн дагуу ажиллах ёстой.

Танай үйлдвэрлэлийн процессын аюулгүйн системүүд хэрхэн ажилладаг талаар та мэдэх үү? Хэрэв ажилчдаас тэдгээр системийн ажиллагааны талаарх ойлголтыг нь асуувал тэдний хариулт хоорондоо хэр зөрөөтэй байх бол? Өндөр эрсдэлтэй бүх системийн хувьд ажиллах **ганцхан** арга зам байх ёстой ба түүнийг хүн бүр мэдэж байх хэрэгтэй.

Үйлдвэрлэлийн процессын хяналтын системийн зорилго бол тухайн процессыг аюулгүй ажиллагааны тогтоосон хэм хэмжээнээс нь хэтрүүлэхгүй байлгах юм (2015 оны 06-р сарын Beacon-ыг харна уу). Хэрэв тухайн процесс тогтоосон хэм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай гэдгийг ойлгох нь маш чухал.

Үүнд ESD (аваарын зогсолт) системийг идэвхжүүлэх зэрэг арга хэмжээнүүд багтана. Ямар арга хэмжээ, хэзээ авах талаар мэдлэг олгох сургалтад операторуудыг хамруулах ёстой.

Аюулгүйн системийн талаарх ойлголт дутуу бол асуудал улам дордох боломжтой. Учир нь ажилчид аюулгүйн системд найдахгүйгээр буруу үйлдэл хийж болзошгүй. Эсвэл тэд аюулгүйн системд мухраар найдаж, тухайн системийн чадамжид хамаарахгүй үйлдлийг хийнэ гэж найдаж болох юм.



Та мэдэх үү?

Аюулгүйн систем (ESD, аваарын зогсолт гэх мэт) нь тухайн процесс эсвэл тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан бүтэц загвар, програмтай, шалгалтаар баталгаажсан байдаг. Бүх өөрчлөлтийг МОС (Өөрчлөлтийн Менежмент)-ийн хяналтаар оруулах хэрэгтэй. (2017 оны 7-р сарын Beacon-ыг харна уу).

Аюулгүйн систем (даралт суллах төхөөрөмж гэх мэт) бол аюул эрсдлээс хамгаалах зорилготой боловч тухайн процессыг хянах үүрэгтэй биш юм. (2016 оны 03-р сарын Beacon: “Аюулгүйн/Хяналтын Төхөөрөмж”-ийн тухай харна уу).

Аюулгүйн систем нь хүчдэл, нарийн хэмжүүрийн хий эсвэл аливаа техникийн алдаа зэрэгт тодорхой тогтоосон хариу үйлдлийг үзүүлдэг. Энэ талаарх мэдээлэл ихэвчлэн шугам хоолой болон нарийн хэмжүүрийн диаграм (PID) дээр тэмдэглэгдсэн байдаг.

Олон компанид “Ажлыг шууд зогсоох эрхтэй” хэмээх журам мөрдөгддөг ба энэ нь ажилчдад хянах боломжгүй үйл ажиллагааг шууд зогсоохыг зөвшөөрдөг, бүр шаарддаг.

Та юу хийж чадах вэ?

Өөрийн ахлах ажилтан эсвэл сургагчаас тухайн аюулгүйн системийн ажиллагааны зарчмыг асууж, нарийн учрыг нь тодруул. Та ихийг мэдэх тусмаа хэрэгцээтэй үед илүү зөв үйлдэл хийх боломжтой.

Дараагийн багийн уулзалт эсвэл аюулгүй ажиллагааны хорооны хурал дээр аюулгүйн системийн тухай сэдвээр хэлэлцүүлэг өрнүүл. Хэрэв системийн үйл ажиллагааны талаар хүн бүр өөр өөр ойлголттой байвал танайд “ноцтой асуудал” байна гэсэн үг!

Үйлдвэрлэлийн Процессын Аюулын Дүн Шинжилгээ (РНА) эсвэл эдгээр чухал хамгаалалтын хэрэгслийн МОС-ийг хянах үед өөрийн мэддэг бүхнийг, ажлын талбай дээр тохиолддог нөхцлийн талаар нээлттэй, үнэн зөвөөр мэдээлэх хэрэгтэй. Аливаа эргэлзээтэй зүйлийг даруй шинжлэн судалснаар системийг бүрэн зөв ажиллуулах боломж бүрдэнэ.

Танай үйлдвэрийн аюулгүйн системүүд хэрхэн ажилладаг талаар мэдлэгтэй бай!